

БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/Ш.НЯМХҮҮ/

"ХУНТ – ӨГӨӨЖ" ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



/Б.БАТ-ӨЛЗИЙ/

2025.05. 01

№2024/01

Баруун-Урт хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу "Хэрлэн голын сав газрын захиргаа"-ны 2025 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн дугаар Е-2503-000250 тоот Ус ашиглах дүгнэлт, Байгаль орчны газрын даргын 2025 оны 04 сарын 29-ний өдрийн А/16 тоот "Ус ашиглуулах зөвшөөрөл"-ийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Байгаль орчны газрын усны нөөцийн ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн П.Болортунгалаг, Ус ашиглагчийг төлөөлж: Сүхбаатар аймаг, Мөнххаан сумын нутагт орших МУ – 016689 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 1811004053 улсын бүртгэлийн дугаартай, 2166631 регистрийн дугаартай "Хунт – Өгөөж" ХХК –ны гүйцэтгэх захирал Б.Бат-Өлзий нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 Ус ашиглах зориулалт: МУ – 016689, 337,57 га ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, хайлуур жоншны хүдрийн ордыг далд аргаар ашиглан гар ялгалт хийх.

2.2 Нийт ашиглах усны хэмжээ: 31302.0 м³/жил

2.2.1 Унд ахуйд: 3000 м³/жил

2.2.2 Олборлох үйлдвэрийн хэрэглээ /шавхалтын ус ашиглана/: 500.0 м³/жил

2.2.3 Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээлтэнд /шавхалтын ус ашиглана/ 500.0 м³/жил

2.2.3 Шавхан зайлуулалт: 27302.0 м³/жил

2.3 Усны чанар, найрлага: Унд ахуйд хэрэглэх усыг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн, цэвэршүүлсэн ус хэрэглэх шаардлагатай.

2.4 Усны эх үүсвэрийн байршил: Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших "Бүдүүн ухаа"-ийн газрын доорх усны орд. Ажиллагсдын унд ахуйн усыг 2012 онд өрөмдөж

гаргасан гүний худгаас хангана. 2015 онд өрөмдөж гаргасан газрын доорхи ус шавхан зайлуулах шүүрлийн 2 цооногтой. Ундрага – 1л/с, гүн-110м, усны тогтоосон түвшин- 27,6м

Цооног-1: Байршил $112^{\circ} 51' 30''$ $47^{\circ} 15' 19,9''$ (босоо ам-1) тооллууртай.

Цооног-2: Байршил $112^{\circ} 49' 38''$ $47^{\circ} 14' 34''$ (босоо ам - 2) тооллууртай.

Үйлдвэр технологийн хэрэгцээнд хоногт 91м^3 усыг шавхан зайлуулах уснаас ашиглана.

2.5 Барилга байгууламж: Мэдээлэл байхгүй. Босоо ам -1-ын зумфэнд ЦНС-38-154 маркийн насос , босоо ам 2-ын зумфэнд ЦНС-38-154 маркийн насос, Босоо ам -1,2 шүүрүүлэх цооногуудад Mastra маркийн насос тус тус суурилуулж LXLG-100, тооллууржулсан. Зумфэнд хуримтлагдсан усыг 219мм-н диаметртэй төмөр хоолойгоор дамжуулан газрын гадаргууд гаргана.

2.6. Хаягдал ус: Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших “Бүдүүн ухаа” гэдэг газарт орших хайлуур жонш орд. Ахуйн хаягдал бохир усны хэмжээ хоногт дундажаар $0,9\text{м}^3$ байна. 365 хоног ажиллана. Ахуйн бохир ус зайлуулах цэг байгуулахдаа Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05-ны өдрийн А/82/128 тоот тушаалаар баталсан журмын дагуу тохижуулж, тоноглох, солбилцолыг авах мөн Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/719/189 тоот тушаалаар баталсан Хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлт болон зөвшөөрлийн бичиг авч гэрээ байгуулах шаардлагатай.

2.7 Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

1. Орон нутагтай хамтран Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг хамтран зохион байгуулах
2. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх
3. Орон нутгаас санал авч булаг шандын эхийг хашиж хамгаалах
4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байх.

2.8 Усны тоолуур: Босоо ам -1,2 – ийн зумф болон шүүрүүлэх цооног бүрт нийт 6 тооллууртай.

Урьдчилсан байдлаар тооцсон ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Тухайн жилд ашиглах 31302.0 м^3 газрын доорхи усны төлбөрийн хэмжээг “Усны экологи- эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Хэрлэн голын сав газарт тогтоосон газрын доорхи усны экологи

эдийн засгийн суурь үнэлгээ, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2013 оны 09 сарын 21-ний өдрийн 237 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, "Усны нөөц, ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох хөнгөлөх" тухай Засгийн газрын 2013 оны 09 сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 416 дугаар тогтоолд заасан хувь хэмжээгээр тооцсон байна.

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м³	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м³ усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Олборлох үйлдвэрийн хэрэгцээн	500	Газрын доорхи ус	0	113.40	56,700	0	56,7000
Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтэд хэрэглэх ус	500	Газрын доорхи ус	0	85.05	42,525	0	42,525
Шавхан зайлуулах	27302	Газрын доорхи ус	0	510.3	13,932,210.60	0	13,932,210.60
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	3000	Газрын доорхи ус	0	127.57	382,725	0	382,725
Нийт	31,302				14,414,160.60		14,414,160.60

Нийт төлбөр 56,700 төг+42,252 төг+13,932,210.60 төг +382,800 төг=14,414,160.60 төг

/арван дөрвөн сая дөрвөн зуун арван дөрвөн мянга нэг зуун жаран/ төгрөг

Хайлуур жоншны хүдрийн ордыг далд аргаар олборлолт хийхэд усны 14,414,160.60 / арван дөрвөн сая дөрвөн зуун арван дөрвөн мянга нэг зуун жаран / төгрөгийг Сүхбаатар аймгийн төрийн сангийн /100120000944/ дансанд төвлөрүүлнэ.

Усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн мэдээ тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлнэ.

Сумын байгаль хамгаалагч ус ашигласны төлбөрийг усны эх үүсвэрт байрлуулсан усны тоолуурын заалтаар бичилтийг хийж, ус авах цэг, газар доорхи усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулахад хяналт тавьж ажиллана. /Усны тухай хуулийн 19.1.2.ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд хяналт тавих;/

Жич: Ус ашигласны төлбөрийг усны эх үүсвэрт байрлуулсан усны тоолуурын заалтаар төлөх бөгөөд тоолуурын заалтыг Мөнххаан сумын татварын байцаагч, байгаль хамгаалагчийг байлцуулан сар бүрийн 20-25-ны дотор авч, дараа сарын 10-ны дотор төлнө. 12-р сарын усны төлбөрийг 12-р сарын 25-ны дотор төлнө.

Мөн үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар зогсолт хийх, эргэн ажиллах бол тухай бүрт нь мэдэгдэж байх.

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1 Ус ашиглуулагч нь Усны тухай хуулийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2 Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.2.1 Усны тухай хуулийн 4.4-д заасны дагуу уурхайн ус хангамжийн эх үүсвэрт гидрогеологийн хайгуулын ажил гүйцэтгүүлж, усны нөөцөө батлуулах, мөн ашигт малтмалын ордын гидрогеологийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, уурхайд орж ирэх шүүрлийн усны хэмжээг нарийвчлан тогтоолгох.

3.2.2 Усны тухай хуулийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх.

3.2.3 Усны тухай хуулийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорхи усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулна.

3.2.4 Усны тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, ус ашиглалтын талаарх Байгаль орчны газар, Сав газрын захиргаа, орон нутагт гаргаж өгөх.

3.2.5 Хаягдал бохир усанд биохимийн шинжилгээг хийлгэж усны тайланд хавсарган Байгаль орчны газарт ирүүлэх.

3.2.6 Ажилчдын ундны усыг стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах.

3.2.7 Ус ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд Байгаль орчны газар, Сав газрын захиргаа, сумын Байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч холбогдох мэргэжилтэнгүүдэд хүсэлт гаргаж газар дээр нь шийдвэрлэж байх.

3.2.8 Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.2.9 Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн бол "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүнин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.


4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
УСНЫ НӨӨЦИЙН АШИГЛАЛТ,
ХАМГААЛАЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

 /П.БОЛОРТУНГАЛАГ/
МӨНХХААН СУМЫН БАЙГАЛЬ
ХАМГААЛАГЧ

/З.ГЭРЭЛЧИМЭГ/

ХАЯГ: СҮХБААТАР АЙМАГ, БАРУУН-
УРТ ХОТ, DG-TOWER 7 ДАХВАРТ

УТАС: 70518892

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ХҮНТ - ӨГӨӨЖ" ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



/Б.БАТ-ӨЛЗИЙ/

ХАЯГ: УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР
ДҮҮРЭГ, 6 ДУГААР ХОРОО, БАГА
ТОЙРУУ МОНРЕИМПЕКС № 505

УТАС: 80115432, 99117550